

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”

Хариуцлагатай Компани

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН



“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр “ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК (Цаашид “Компани” гэх) нь 2005 оны 7-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор хувьцаат компани болон шинэчлэн зохион байгуулагдсан.

Гэрчилгээ 2005 оны 10-р сарын 11-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, Улсын бүртгэлийн 2688565 регистрийн дугаар бүхий 9010001004 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

Үндсэн үйл ажиллагаа “Компани”-ийн үндсэн үйл ажиллагаа нь Цахилгаан эрчим хүч түгээх, цахилгаан эрчим хүчийг хангах, Цахилгаан эрчим хүчний шугам болон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ хийх, гадаад дотоод худалдаа эрхлэх зэрэг болно.

Тусгай зөвшөөрөл Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу Эрчим хүчний зохицуулах газраас Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 сарын 26-ны өдрөөс 20 жилийн хугацаатай авсан.
Мөн Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Эрчим хүчний зохицуулах газраас Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт Цахилгаанаар зохицуулалтай хангах тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 сарын 26-ны өдрөөс 20 жилийн хугацаатай авсан.

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо (ширхэг)	Хувьцааны нэг бүрийн үнэ (төгрөг)
	10,385,116	100.00

Гүйцэтгэх Удирдлага	Гүйцэтгэх захирал	Ц.Хангай
	Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэ-сугар

Байнгын хаяг **ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК**
Дархан-Уул сум 3-р баг
Дархан-Уул аймаг, Монгол улс

Аудитор **“ЭВИДЕНСЕ АУДИТ” ХХК**
Хоймор оффис 502 тоот Алтайн гудамж
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо,
Улаанбаатар хот, Монгол Улс

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлангийн 5-6 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” Хувьцаат Компанийн (Цаашид “Компани” гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

“Компани”-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

Ц.ХАНГАЙ
Гүйцэтгэх захирал

Л.ЭРДЭНЭСУГАР
Ерөнхий нягтлан бодогч

Огноо: 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдөр



“ЭВИДЕНС-АУДИТ” ХХК

Аудит, аутсорсинг

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, 7-р хороолол, Алтайн гудамж, 281,
Хойморь оффис, 502 тоот, Регистр № 5211875,
Утас, факс: 976-7000-7121

E-mail: info@evidenceaudit.mn

Огноо: 2026 оны 03 сарын 09 № 30 /2026

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ

СҮЛЖЭЭ” ХК-ийн

Удирдлагад

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Санал дүгнэлт

Бид “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн (цаашид “Компани” гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

- 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан
- Энэ өдрөөрх жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд

Бидний дүгнэлтээр, “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа “Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага” гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ Санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.


ДЭНХТУЯА
ЭВИДЕНС-АУДИТ ХХК
Хоймор-оффис 502-р оот Алтайн гудамж
Сүхбаатар дүүрэг 9-р хороо,
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо 2026.03.09

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Тод	(төгрөгөөр)	
		12/31/2024	12/31/2025
Борлуулалтын орлого	5	148,508,757,364	199,876,615,466
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6	150,954,339,655	202,278,657,040
Нийт ашиг (алдагдал)		(2,445,582,291)	(2,402,041,574)
Бусад орлого	7	9,367,483,390	5,950,611,418
Ерөнхий ба удирдлагын зардал	8	1,280,839,732	1,177,614,668
Санхүүгийн зардал	9	53,376,355	62,332,287
Бусад зардал	10	4,686,469,396	2,153,315,354
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	11	37,947,732	6,225,923
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	12	2,028,752	(6,286,003)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		861,239,133	155,247,456
Орлогын татварын зардал		86,694,403	15,524,746
Татварын дараах ашиг (алдагдал)		774,544,730	139,722,710
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		774,544,730	139,722,710

Энэхүү Орлогын дэлгэрэнгүй тайланг 7-оос 34 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших
бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

		(төгрөгөөр)	
Үзүүлэлт	Тод	12/31/2024	12/31/2025
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13	159,865,432	204,326,808
Дансны авлага	14	2,525,564,871	3,432,621,112
Татварын авлага	15	80,000,000	21,236,000
Бусад авлага	16	3,535,949,342	5,278,740,816
Бараа материал	17	5,336,566,849	4,347,774,242
Урьдчилж гарсан зардал	18	320,565,427	2,023,585,851
Эргэлтийн хөрөнгийн дүн		11,958,511,922	15,308,284,829
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	19	105,739,673,852	109,467,588,035
Биет бус хөрөнгө	20	718,220,463	760,255,674
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		106,457,894,316	110,227,843,710
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		118,416,406,238	125,536,128,539
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	21	3,586,488,030	13,411,349,993
Цалингийн өглөг	22	2,849,358,717	1,503,274,559
Татварын өр	23	1,205,758,096	1,311,022,471
НДШ-н өглөг	24	672,879,450	88,529,828
Банкны богино хугацаат өр төлбөр	25	649,887,400	931,389,716
Урьдчилж орсон орлого	26	20,000,000	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		8,984,371,694	17,245,566,567
Урт хугацаат өр			
Урт хугацаат өр төлбөр	27	1,458,634,967	501,626,928
Хойшлогдсон татварын өр төлбөр	28	12,148,048,489	12,042,920,960
Урт хугацаат өр төлбөрийн дүн		13,606,683,456	12,544,547,888
Өр төлбөрийн нийт дүн		22,591,055,150	29,790,114,455
Эздийн өмч			
Өмч: /хувийн/		1,038,511,577	1,038,511,577
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		93,906,236,904	93,787,177,189
Хуримтлагдсан ашиг		780,602,607	920,325,318
Эздийн өмчийн дүн		95,725,351,088	95,746,014,084
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		118,316,406,238	125,536,128,539

Энэхүү Санхүү байдлын тайланг 7-оос 34 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
12/31/2024	1,038,511,577	93,906,236,904	780,602,608	95,725,351,088
Өмчид гарсан өөрчлөлт			(0.19)	(0.19)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(119,059,714)		(119,059,714)
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/	-		139,722,710	139,722,710
12/31/2025	1,038,511,577	93,787,177,189	920,325,318	95,746,014,084

Энэхүү Өмчийн өөрчлөлтийн тайланг 7-оос 34 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших
 бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	(төгрөгөөр)	
Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	137,060,431,594	182,423,511,860
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	123,447,330,146	170,515,708,411
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,612,206	25,820,036
Бусад мөнгөн орлого	13,610,489,241	11,881,983,412
Мөнгөн зарлагын дүн (-)	133,157,557,284	177,516,033,455
Ажилчдад төлсөн мөнгө	12,850,842,358	17,568,748,904
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,151,148,016	5,143,252,508
Бараа материал худалдан авахад төлсөн	13,653,481,460	18,110,517,455
Ашиглалтын зардал төлсөн	49,518,624	58,362,731
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,189,345,044	1,380,320,897
Хүүний төлбөрт төлсөн	6,494,311	97,568,656
Татварын байгууллагад төлсөн	2,380,678,219	4,209,718,615
Даатгалын төлбөрт төлсөн	74,749,809	124,286,307
Бусад мөнгөн зарлага	99,801,299,443	130,823,257,382
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	3,902,874,310	4,907,478,405
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	4,360,345	8,404,426
Хүлээн авсан хүүний орлого	4,360,345	8,404,426
Мөнгөн зарлагын дүн (-)	3,444,323,468	4,143,630,627
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,369,427,155	3,006,278,847
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	338,453,250	194,837,980
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	736,443,062	942,513,801
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(3,439,963,123)	(4,135,226,202)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	446,616,175	-
Зээл авсан, өрийн шнэт цаас гаргаснаас хүлээн авсан	446,616,175	-
Мөнгөн зарлагын дүн (-)	663,178,084	727,790,827
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	662,038,357	714,649,201
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	1,139,727	13,141,626
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн дүн	(663,178,084)	(727,790,827)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(200,266,897)	44,461,376

Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(200,266,897)	44,461,376
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	360,132,329	159,865,432
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159,865,432	204,326,808

Энэхүү Мөнгөн гүйлгээний тайланг 7-оос 34 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт
униших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.